

БАТЛАВ: ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА
С.БАТБОЛД



АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 03 сарын 26 -ны өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо Засгийн хаягт байрлах, "Зам, тээврийн хөгжлийн яам" (цаашид "Захиалагч" гэх) түүнийг төлөөлж, Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, нөгөө талаас Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 2-р 40 мянгат, 35-р байр, 40 тоот хаягт орших 5347513 регистрийн дугаартай "ПРО МЕДИА НЕТВОРК" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх) түүнийг төлөөлж, Түншлэлийн албаны дарга Э.Төгөлдөр нар Монгол Улсын Иргэний хуулийн 31 дүгээр бүлгийг үндэслэн, харилцан тохиролцож, энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн өгсөн гүйцэтгэх ажлын хүрээ, зааварчилгаа буюу 1.2-т заагдсан хамтран ажиллах нөхцөлийн дагуу ажлыг гүйцэтгэх, Захиалагч нь Гүйцэтгэгчид энэхүү гэрээний дагуу харилцан тохиролцсон ажлын хөлс төлөхтэй холбогдон үүсэх харилцаа, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлно.
- 1.2. Хамтран ажиллах нөхцөл: Хавсралт дахь үнийн саналын дагуу 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр "Эдийн засгийн чуулган 2022" форумын урьдчилсан хэлэлцүүлэг "Боомтын сэргэлт" хурлын медиа багцын ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 1.3. Талууд аливаа мэдээ мэдээллийг гаргахдаа Олон нийтийн радио телевизийн тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль болон Монгол улсад үйлчилж буй холбогдох хууль тогтоомжуудыг удирдлага болгон түүнийг хэрэгжүүлж ажиллана.

ХОЁР. ХУГАЦАА

2.1 Талууд энэхүү гэрээг 2022 оны 03 сарын 26-ны өдрөөс эхлэн 2022 оны 04 сарын 20-ний өдрийг дуустал хугацаанд байгуулав.

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО

3.1 Гүйцэтгэх ажлын төлбөр нь 18,000,000 (арван найман сая) төгрөг байх бөгөөд энэхүү үнэд НӨАТ багтсан болно.

3.2 Захиалагч нь Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийг Гүйцэтгэгчийн дараах дансанд шилжүүлнэ.

Данс эзэмшигч: Про медиа нетворк ХХК

Дансны дугаар: 453 175 468

Банк: Худалдаа хөгжлийн банк

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Захиалагч нь дараах эрхтэй. Үүнд:

4.1.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;

4.1.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээний нөхцөлийг биелүүлэх боломжгүй болох нь илэрхий болсон тохиолдолд өөрийн санаачилгаар гэрээг цуцлах, учирсан хохирлоо Гүйцэтгэгч талаар гаргуулах;

4.2 Захиалагч нь дараах үүрэг. Үүнд:

4.2.1. Шторкнд ашиглах алдаагүй, чанарын шаардлага хангасан мэдээллийг Гүйцэтгэгчийн (tuguldur@tngr.tv) цахим шуудан руу илгээх;

4.2.2. Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд нэхэмжлэхийн дагуу гүйцэтгэгчийн дансанд шилжүүлэх;

4.3 Гүйцэтгэгч нь дараах эрхтэй. Үүнд:

4.3.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Захиалагчаас шаардах;

4.3.2. Гэрээний төлбөрийг гэрээнд заасан журмын дагуу шилжүүлэхийг Захиалагчаас шаардах;

Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

4.3.3. МЭЗЧ-ны урьдчилсан хэлэлцүүлгийг Тэнгэр телевизийн эфирээр дуу, дүрсний өндөр чанартайгаар бүтэн шууд дамжуулах;

4.3.4. Захиалагчаас цахим шуудангаар ирүүлсэн материалын дагуу шторкыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх;

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Аль нэг Тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө Талдаа хохирол учруулсан тохиолдолд бодит хохирлыг буруутай Тал нь нөхөн төлнө.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ

6.1 Энэхүү гэрээ болон гэрээтэй холбогдуулан талуудын шууд болон шууд бусаар олж авсан аливаа мэдээллийг Байгууллагын нууцын тухай хууль болон Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу задруулахгүй байх үүргийг талууд хүлээнэ.

ДОЛОО. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ЦУЦЛАХ

7.1 Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар гэрээний хугацаанд хүчинтэй байна;

7.2 Гэрээний хүчинтэй хугацаанд гэрээнд гарын үсэг зурсан эрх бүхий этгээд өөрчлөгдсөн нь гэрээг дуусгавар болгох үндэслэл болохгүй;

7.3 Хэрэв Захиалагчийн зүгээс гэрээг хугацаанаас өмнө цуцлах санал гаргавал Гүйцэтгэгч нь гэрээ цуцлагдах хүртэл хугацаанд гүйцэтгэсэн ажлын хөлсийг Захиалагчаас нэхэмжлэх бүрэн эрхтэй байна;

7.4 Гэрээг дараах тохиолдолд хугацаанаас өмнө цуцалж болно.

- Талууд харилцан тохиролцсоноор;
- Энэхүү гэрээнд заасан үндэслэлээр;
- Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээр

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1 Холбогдох хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд ажил гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно;

8.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга, цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм, ажил хаялт зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно;

8.3 Талуудын гэрээний үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй нь давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалсан нь тогтоогдвол хариуцлагаас чөлөөлөгдөнө.

ЕС. БУСАД

9.1 Гэрээний хугацаанд талууд хоорондоо солилцох бүхий л мэдээлэл ба харилцаа нь талуудын албан ёсны хаягаар дамжин албан бичиг болон и-мэйлээр баталгаажна;

9.2 Гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэж, Захиалагч тал 1 эх хувь, Гүйцэтгэгч тал 1 эх хувь гэрээг хадгална. Эх хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчин төгөлдөр байна;

9.3 Талуудын харилцан тохиролцсоноор бичгээр оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

Гэрээний дугаар:

Хавсралт №1

Ажил, үйлчилгээ	Тайлбар	Хэмжих нэгж	Ажил, үйлчилгээ
Шууд дамжуулалт, зохион байгуулалт	МЭЗЧ-ны урьдчилсан хэлэлцүүлгийн шууд дамжуулалт 4-5 цаг, бусад хэвлэлд зориулсан шууд дамжуулах сигнал (Мөн зочдыг урих, угтах, чиглүүлэх)	5-8 цаг	₮18 сая, НӨАТ орсон.
Танилцуулга видео	Панел хэлэлцүүлэг бүрийн эхэнд тоглуулах танилцуулга шторк	4ш	
Медиа идэвхжүүлэлт, ярилцлага, подкаст, сурвалжилга	Арга хэмжээний өмнө болон дараах медиа идэвхжүүлэлт, тусгай ярилцлагууд, сурвалжилга, подкаст, мөн бусад хэвлэлийг хариуцана.	10+	
Нэгдсэн хэвлэлийн хурал	Урьдчилсан хэлэлцүүлгийн нэгдсэн хэвлэлийн хурал зохион байгуулах	1 удаа	
Медиа бүүт ажиллуулах	Хэлэлцүүлгийн үеэр медиа бүүт ажиллуулах, хэвлэл мэдээллийг мэдээллээр хангах	-	
Бусад хэвлэлийн шууд дамжуулалт	Тэнгэр телевизийн шууд дамжуулалтын үндсэн сигналыг ашиглан бусад хэвлэлээр шууд дамжуулна	6 телевиз, 2-4 Сайт, Facebook хуудас	

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч талыг төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:


Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Д.Гэрэлням /........../

Түншлэлийн албаны дарга

Э.Төгөлдөр /........../

Хуулийн хэлтсийн дарга

Төлөөлөгч зураг нь гүйцэтгэгчийн хөшөөг харуулж байна
Н.Бат-Эрдэнэ /........../

89119817

СХОХ-ийн ахлах шинжээч

Г.Алтангэрэл /........../

НЭХЭМЖЛЭХ Н-022/4-007



Улаанбаатар, ЧД 1-р хороо
2-р 40 мянгат
35-р байр 40 тоот

Утас: +(976) 9950 1821

Имэйл agiimaa@tngr.tv

Вэб: www.tngr.tv

Төлөгч:

Зам тээврийн хөгжлийн яам

Нэхэмжилсэн огноо:

2022-04-06

Төлөх сүүлийн хугацаа:

2022-04-09

Ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1 Шууд дамжуулалт	1	18,000,000 ₮	18,000,000 ₮



НИЙТ ДҮН (НӨАТ багтсан) 18,000,000 ₮

Дансны мэдээлэл:

ХХБ - 453175468

Хүлээн авагч:

Про медиа нетворк ХХК